

**Улаанбаатар: ӨНӨӨДӨР**



**Өдөр +26**  
**Шөнө +14**

**УЛС ТӨР**

АН-ЫН БҮЛЭГ УИХ-ЫН ЭЭЛЖИТ  
БУС ЧУУЛГАНЫГ ХУРАЛДУУЛАХЫГ  
ДАХИН ШААРДАВ

**V нүүрт**

**ЧУХАЛ ХҮН**

Н.ЦЭЦЭГМАА: ЭРЧҮҮДЭД СЭТГЭЛИЙН  
ДЭМ, УРМЫН ҮГ ИХ ХЭРЭГТЭЙ

**VI-VII нүүрт**

Дугаарын **60** мөр

Даргын тамга  
хэр үнэтэй вэ

Б.СУМЬЯА

Энэ асуулыг цагтаа тодорхой албан тушаал хашиж, байгууллага хамт олныг удирдаж явсан дарга нараас асуумаар байна. Магадгүй хүн бүр өөр өөрийнхөөрөө л харуулах биз. Гэхдээ хэдий хэрийн үнэтэй эд болоод түүний араас үхэн хатан зүтгэж, авч зүтгэдэг нь сонирхол татна. Ерөөс сонгууль бүрийн дараа ийм үзэгдэл гарах болжээ. Саяхны жишээ гэхэд, Баянзүрх дүүргийн газрын албаны ажил "даргын тамгагүй" бүтэн сар гацаж буй тухай мэдээлэл хэвлэлээр цацагдсан. УИХ-ын сонгуулийн дараа тус газрыг түр удирдаж байсан эрхэм тамга тэмдэг, албан бланкуудаа авч яваад сураг алдарсан гэх. Гэтэл албан тушаалд томилогдох, огцрох нь хууль журмын дагуу шийдэгддэг учиртай.

ҮЗЭЛ БОДОЛ

## ТАВАНТОЛГОЙГОО

# “ЦАВЧААЧИД”-ЫН ГАРААС САЛГАЖ, ЗЭЭЛЭЭ ТЭГЛҮҮЛЬЕ

Н.ПУНЦАГБОЛД

Ерөнхийлөгчийн сонгууль өнгөрсөн зургадугаар сарын 26-нд болсон. Гэхдээ эхний удаагийн санал хураалтаар гурван нэр дэвшигчийн хэн нь ч сонгогчдын 50-наас дээш хувийн санал авч чадаагүй. Улмаар долдугаар сарын 7-нд хоёр дахь шатны санал хураалт болж, АН-аас нэр дэвшигч Х.Баттулга Ерөнхийлөгч болсон. Тэгвэл долдугаар сарын 1-ний өдөр АН-ын зүгээс нэр дэвшигчид хэрвээ Ерөнхийлөгч болбол монголчуудыг зэвлэнэс нь салгаж өгөх санал хүргүүлсэн юм. Түүнээс хойш өнөөдрийг хүртэл энэ асуудал “хэрүүлийн алим” хэвээр байсаар байна. Ерөнхийлөгч тангаргаа өргөөд удаагүй байхад л зарим нэг хүн хэвлэлийн хурал зарлаж, өр дарж өгөөрэй хэмээн “омогдож” байлаа.



ОНЦЛОХ МЭДЭЭ



### Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ТАСС агентлагт ярилцлага өглөө

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга энэ сарын 15-нд ОХУ-ын мэдээллийн ТАСС агентлагт ярилцлага өгсөн байна. ТАСС агентлагийн ахлах сурвалжлагч Алексей Селищев Монгол Улсын Ерөнхийлөгчийн цаашид баримтлах гадаад бодлого болон Монгол-ОХУ хоорондын хамтын ажиллагааны хэтийн төлвийн талаар сонирхсон асуултауддаа хариулт авчээ. Мөн энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ирэх эсдүгээр сард ОХУ-ын Владивосток хотноо болох Дорнын эдийн засгийн чуулга уулзалтад оролцох талаараа ярьжээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга тангараг өргөж, бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойш анх удаа гадаадын хэвлэл мэдээлэлд ярилцлага өгч байгаа нь энэ ажээ.

ДЭЛХИЙ

### Д.Трампын мэдэгдлээс үүдэж, зөвлөлийн таван гишүүн огцорлоо

Б.ДАВАА

АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трамп сонгуульд ялалт байгуулж, энэ оны нэгдүгээр сарын 20-нд тангаргаа өргөж, өөрийн кабинетаа бүрдүүлэн ажлаа эхэлснээс хойш тав дахь хүн албан тушаалаасаа огцорлоо. Тодруулбал, АНУ-ын Хөдөлмөрийн холбооны бага хурлын дарга Ричард Трумка Ерөнхийлөгчийн зөвлөх байгууллага буюу “АНУ-ын аж үйлдвэрийн зөвлөл”-ийн гишүүнийг хэсэг суудлаас огцроход хүрсэн байна. Түүний огцрох болсон шалтгаан нь энэ сарын 12-



ны өдөр Виржиниа мужийн Чарлоттсвиллд гарсан үндсэрхэг үзэлт цагаан арьстнууд болон тэднийг эсэргүүцэгчдийн хооронд болсон мөргөлдөөнтэй холбоотой аж.

Үргэлжлэл нь V нүүрт

FINE MECHANICAL WATCHMAKING, FROM JAPAN.

## PRESAGE



TRIMATIC

Trimatic symbolizes three Seiko inventions that ensure the highest levels of reliability and durability in its mechanical watches.

## SEIKO



SEIKO BOUTIQUE - 1  
SEIKO BOUTIQUE - 2  
SEIKO SHOP - 1  
SEIKO SHOP - 2

Наран Плаза, 4-р давхар, Чингисийн өргөн чөлөө-29  
Наран Молл, 2-р давхар, Сүүлийн гудамж -42/1  
Наран Пойнт, Хувьсгалчдын гудамж - 9  
Наран Центр, УИД-ын баруун талд, Энхтайваны өргөн чөлөө

Утас: 99926756  
Утас: 88099991  
Утас: 11-326435  
Утас: 88039397

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2437.00	2451.00	ФУНТ	3097.00
ЕВРО	2832.00	2892.00	РУБЛЬ	40.00
ИЕН	21.94	22.35	ЮАНЬ	363.50
			Авах	Зарах
			АМ.ДОЛЛАР	2440.00
			ЕВРО	2845.00
			ИЕН	21.81
			ФУНТ	3109.00
			РУБЛЬ	40.01
			ЮАНЬ	363.00

# УЛС ТӨР

## АН-ын бүлэг УИХ-ын ээлжит бус чуулганыг хуралдуулахыг дахин шаардав

УИХ дахь Ардчилсан намын бүлэг энэ сарын 15-нд ээлжит бусаар хуралдаж, Засгийн газрын зарим сайд нараас өвөлжилтийн бэлтгэл ажлыг хэрхэн хангаж байгаа тухай болон бусад асуудлаар мэдээлэл сонссон юм. Энэ талаар УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат, дэд дарга Ж.Батзандан, Ажлын албаны дарга Д.Золжаргал нар өчигдөр мэдээлэл хийлээ.

**Д.Эрдэнэбат:** Бид зүгээр л боловсролын материал техникийг хангадаг яамтай болчихоод байна

БСШУС-ын сайд Г.Чулуунбаатарын мэдээлэлтэй холбоотойгоор УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж Багшийн хөгжлийн тухай хуулийн төслийн асуудлыг хөнджээ. Тэрбээр Багшийн хөгжлийн тухай хууль бол багшийн хөгжлийн эсрэг хууль болсон бөгөөд Боловсролын хуулиар хүрсэн төвшнөөс буусан олон заалт байгааг дуулгав. Тиймээс УИХ-ын гишүүн Н.Учрал, УИХ дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж болон салбар яамны холбогдох хүмүүсийг оруулан ажлын хэсэг байгуулж ажиллахыг хүслээ. Харин АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат “Төрийн нэгдсэн бодлого дутагдаж байгаагаас болоод энэ салбарын өдөр тутмын үйл ажиллагаа хүндэрсэн.



Бид зүгээр л боловсролын материал техникийг хангадаг яамтай болчихоод байна. Цаашид боловсролын эрх зүйн орчинг сайжруулах хэрэгтэй. Боловсролын, Дээд боловсролын, Технологийн, Инновацийн тухай хуулийг өөрчилж, дипломны хүмүүсийг л бэлтгэдэг байдлаасаа татгалзаж боловсон хүчний бодлоготой болох эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлэх шаардлагатай байна. Мөн Боловсролын салбарын хувьд өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотойгоор хэд хэдэн асуудал байна. Тухайлбал, орон нутгаас ирж байгаа оюутны дотуур байрны асуудал, харьяалал харгалзахгүй оюутны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг болох, дутагдалтай байгаа сургууль, цэцэрлэгийн асуудлуудыг анхаараххэрэгтэй” гэв.

**Ж.Батзандан:** Хувийн сургууль, цэцэрлэгүүдийн төлбөрийг хуулиар зохицуулах ёстой

УИХ дахь АН-ын бүлгийн дэд дарга Ж.Батзандан “Бид боловсролын сайдад хэд хэдэн асуудлаар чиглэл өгсөн. Нэгдүгээрт, Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө оюутны төлбөрийг нэмэхгүй байх шийдвэр гаргасан. Энэ шийдвэртээ хатуу зогсоорой гэдэг шаардлага тавьсан. Хоёрдугаарт, цэцэрлэгийн асуудлыг анхааралдаа онцгойлон авч шийдвэрлэх чиглэл өглөө. Монгол Улсын нийт хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулахын тулд өмнөх Засгийн газар хүүхэд харах үйлчилгээг гаргасан.

Гэвч энэ ажлыг хүчингүй болгочихсон. Үүний оронд шинэ цаг үетэйгээ нийцсэн шийдэл гаргаж ирэхгүй байна. Гуравдугаарт, хувийн дунд сургууль, цэцэрлэгүүдийн төлбөрийн асуудал хяналтаас гарлаа. Монголд 40-50 сая төгрөгийн төлбөртэй сургууль байна. Тиймээс АН-ын бүлгээс хувийн сургууль,

...Гэтэл валютын ханш яагаад өссөн талаар судалгааг Сангийн яам дүгнэлт гаргаагүй байгаа гэнэ. Валютын ханш нэмэгдэх хэдхэн шалтгаан байгаа. Эдгээр шалтгааны аль нь вэ гэдгийг Монголбанк, Сангийн яам хоёр зайлшгүй дүгнэлт гаргаж, АН-ын бүлэгт танилцуулах үүргийг өглөө...

цэцэрлэгүүдийн төлбөрийг хуулиар зохицуулах ёстой гэдэг байр суурийг гаргаж байгаа. Үүнтэй холбоотойгоор энэ чиглэлийн хуулийг оруулж ир гэдэг шийдвэрийг салбарын сайдад нь хүргүүлсэн” гэлээ.

**Эрчим хүчний дутагдал, дулааны эх үүсвэрийг шийдэх хэрэгтэй гэв**

Эрчим хүчний цаашид салбарын бодлогыг зөв болгож, УИХ-ын гишүүдэд, олон нийтэд ойлгомжтой болгож өг гэдэг шаардлагыг Эрчим хүчний сайд П.Ганхүүд тавьжээ. Мөн эрчим хүчний дутагдлыг хэрхэн нөхөх, цаашид дулаан, цахилгаан эрчим хүчний ямар шинэ байгууламж барих гэж байгаа тухай нэгдсэн мэдээлэл өгөх шаардлагатай байна. Тухайлбал, Шивээ овоо дээр БНХАУ-тай 6000 МВт-ын станц барих, Английн компаниар 600 МВт-ын станц баруулахаар болж байгаа гэх зэргээр ойлгомжгүй зүйлс олон байна. Түүнчлэн бүлгийн гишүүдийн зүгээс зүүн бүсийн дулаан цахилгааны эрчим хүчний асуудал дээр Чойбалсангийн ДЦС-ын 50 МВт-ын өргөтгөлийг маш яаралтай шийдэх тухай асуудал бүрхэг байна. Үүнийг маш яаралтай шийдэх хэрэгтэй байна гэдгийг сайдад нь дуулгасан. Орон даяар өвөлжилтийн бэлтгэл ажил хэвийн үргэлжилж байгаа энэ үед эрчим хүчний дутагдал, дулаан цахилгааны эх үүсвэрийг хэрхэн шийдэх хэрэгтэй. Түүнчлэн өмнөх Засгийн газрын үед Баян-Өлгий аймагт усан цахилгаан станц барих тухай бүх бичиг баримт, ТЭЗҮ нь хийгдчихсэн

байсан. Үүнийг цаашид явуулах шаардлагатай байна. Түүнчлэн өмнөх Засгийн газрын үед эхэлсэн Багануурын ДЦС-ын асуудал, 10 аймгийг дулаанаар хангахаар хувийн хэвшлийдтэй гэрээ хийсэн байсан ажил гацаанд орчихлоо. Энэ ажлыг болохыг бүлгийн гишүүд сануулсан. Ер нь энэ мэт цаашид эрчим хүчний салбарыг хэрхэн авч явах талаар бодлого боловсруулж, АН-ын бүлэгт мэдээлэл бэлтгэж өгөхийг хүслээ.

**Хадлан тэжээлийн нөөц бэлтгэлтэд онцгой анхаарахыг сануулав**

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг ХХААХҮЯ-ны дэд сайд Ж.Саулегээр ахлууланажиллаж байна. Салбар яамныхны хэлж буйгаар энэ жил зуншлага оройтсон. Онцгой эрсдэлтэй өвөл болно. Анхны цаснаар зуд болох магадлалтай тул бэлтгэлээ хангаж, хадлан тэжээлийн нөөц бэлтгэх ажилд онцгой анхаарч байгаагаар хэлэв. Хэрвээ хадлан өвс дутуу байгаа бол хөрш орнуудаасаа авах асуудлыг судлах цаг хугацаа бага болчихсон учраас хөрөнгө санхүүгийн асуудлыг хийхийн тулд яаралтай УИХ-ыг ээлжит бусаар хуралдуулж, төсвийн тодотголоо хийх хэрэгтэй гэдэг саналыг бүлгийн дарга Д.Эрдэнэбат хэлсэн юм.

**Хүүхдийн мөнгийг ес, аравдугаар сард олгогдохгүй байх эрсдэл үүссэн гэв**

Сангийн яамны мэдээллэд

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчлаланы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**  
**Э.САЙНЗАЯА 99197866**

Дугаарыг эрхэлсэн **Н.ПУНЦАГБОЛД**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

**Редакцийн хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот


“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, Чөлөөт хэвлэл сан-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

## Ерөнхийлөгч Х.Баттулга Франц болон Арабын Элчин сайд нарыг хүлээн авч уулзав

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга өчигдөр Франц болон Арабын Элчин сайд нарыг хүлээн авч уулзав. Эхлээд Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Элизабет Барсакийг хүлээн авч уулзсан бөгөөд Монголын хөдөө, орон нутгаар аялж сэтгэл дүүрэн ирснээ яриад “Монгол өргөн уудам нутагтай ч Улаанбаатарт хүн ам хэт төвлөрсөн, тэврийн хэрэгсэл олон. Газар нутгийн зохион байгуулалтын асуудал энд харагдаж байна” гээд Францад 1950-иад оны эхээр мөн ийм байсан. Бүхэл бүтэн бодлого боловсруулж, Парис хотоос гадагш жижиг дагуул хотууд байгуулж төвлөрлийг сааруулсан. Өвлийн улиралд Улаанбаатарт агаарын бохирдол их байдаг нь мөн төвлөрөлтэй холбоотой хэмээж байлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Таны өмнөх Элчин сайдтай бид ХАА, спортын чиглэлээр хамтарч ажиллаж байсан. Сая таны хэлдэг бүхэн бүгд үнэн. Төвлөрлийг сааруулж байж

эдгээрийг арилгана. Монгол Улс, Бүгд Найрамдах Франц Улсын харилцаа урт удаан хугацааны түүхтэй боловч харамсалтай нь худалдаа, эдийн засгийн харилцаа жил жилээр буурч байна” гээд эдгээр салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар Элчин сайдтай санал солилцон ярилцлаа. Элчин сайд Элизабет Барсак ХАА-н салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь ЭСЯ-ны хийх чухал ажлын нэг гэдгийг онцлоод энэ талын харилцааг хөгжүүлэх бодитой боломж бий гэлээ. Франц Улс нь ХАА-н үйлдвэрлэлээр Европт нэгдүгээр ордог юм байна. Мөн ноолуурын салбарыг тогтвортой хөгжүүлэх, цөлжилттэй тэмцэх хэрэгтэйг Элчин сайд дурьдсан юм.

Уулзалтын үеэр Элчин сайд Элизабет Барсак Монгол Улсын Төрийн тэргүүнээр сонгогдсонд нь баяр хүргэн Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Э.Макроны илгээсэн захидлын эх хувийг гардуулав. Мөн



Францын Үндэсний Ассамблей дахь Франц-Монголын бүлгийн даргын мандчилгээг гардуулсан юм. Уулзалтын төгсгөлд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол-Францын улс төр, бизнесийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх тал дээр хамтарч ажиллахаа илэрхийллээ. Мөн энэ өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Арабын Нэгдсэн Эмират Улсын Элчин сайд Абдулла Абдулрахман Абдуллабин Рабия Аль Тинижиг Хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр ажиллаж буйг дурдаад Эрхөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих тухай хэлэлцээр

Аль Тинижиг Монгол Улсын Төрийн тэргүүнээр сонгогдсонд нь Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад баяр хүргэсэн Арабын Нэгдсэн Эмират Улсын Ерөнхийлөгч Шейх Халифа Бин Зайед Аль-Нахьяан болон дэд Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний командлагч нарын мандчилгээг уламжлав. Элчин сайд Абдулла Абдулрахман Абдуллабин Рабия Аль Тинижиг хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр ажиллаж буйг дурдаад Эрхөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих тухай хэлэлцээр

АН-ын бүлэг гурван зүйлийг онцолж яриу. Нэгдүгээрт, өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой Сангийн яамны хөрөнгийн санхүүгийн нөөц ямар байгаа талаар мэдээлэл авлаа. Сангийн яамны дэд сайд “Хөрөнгийн боломж байгаа. Харин үүнийг төсвийн тодотголд суулгахгүйгээр шийдэж болохгүй байна” гэдэг мэдээллийг өгсөн байна. Тиймээс ч бид УИХ-ын ээлжит бусаар хуралдуулахыг УИХ-ын даргаас шаардсан. Гэвч өнөөдрийг болтол хариу өгөөгүй байгаа учраас дахин шаардах болно гэдгийг бүлгийн дарга Д.Эрдэнэбат хэллээ. Мөн ес, аравдугаар сард 110 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгийг дутагдалд орж, хүүхдийн мөнгө олгогдохгүй байх эрсдэл үүсч байгаа. Мөн өвөлжилтийн бэлтгэл ажил хийх хэрэгтэй байна. Тиймээс ч ээлжит бус чуулганы яаралтай хуралдуулах хэрэгтэй байна. Сангийн яамтай холбоотой дараагийн асуудал бол валютын ханшийн асуудал. Сангийн яамны мэдээллээр өнгөрсөн хугацаанд төсвийн орлого нэмэгдсэн. Гол үндсэн шалтгаан нь нүүрсний үнэ нэмэгдсэн, борлуулалт хоёр дахин өссөнтэй холбоотой гэж тайлбарлаж байгаа. Нүүрсний үнэ болоод борлуулалт нэмэгдэхэд валютын ханш савлааг байгаа нь ойлгомжгүй байна. Өнөөдөр валютын ханш 2450 болж, гурван сарын дотор 300 төгрөгөөр савлаж байгаа. Энэ нь эдийн засагт олон хүндрэлийг үүсгэж байна. Гэтэл валютын ханш яагаад өссөн талаар судалгааг Сангийн яам дүгнэлт гаргаагүй байгаа гэнэ. Валютын ханш нэмэгдэх хэдхэн шалтгаан байгаа. Эдгээр шалтгааны аль нь вэ гэдгийг Монголбанк, Сангийн яам хоёр зайлшгүй дүгнэлт гаргаж, АН-ын бүлэгт танилцуулах үүргийг өглөө. Түүнчлэн ОУВС-ийн асуудалтай холбоотойгоор банкинд магадлан үнэлгээ хийх ажлын хэсэг дээр банкны барьцаанд мал болон хайгуулын лиценз авахыг буруу гэж үзсэн гэсэн дүгнэлт гарсан байсан. Энэ нь манай улсын онцлог нөхцөлд тохиромжгүй. Мөн банкны барьцаанд юуг авах үгүйгээ манай улс өөрийн хуулиар шийдэж байгаа. Үүнийг гадны байгууллагын шахалтаар үгүйсгэх юм бол Монголын бүх банк дампуурах эрсдэл хүлээх болно. Тиймээс энэ асуудалд Сангийн яамныг онцгойлон анхаарахыг санууллаа.



# УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

## Э.Номинчулуун: ХЯТАДЫН ЗАРИМ ХЭРЭГЛЭГЧИД МАНАЙ НҮҮРСИЙГ СОНИРХОЖ БАЙНА

Б.СУМЬЯА

“Багануур” ХК-ийн захиралтай цаг үеийн асуудлаар ярилцлаа.

“Багануур”-ын уурхай ирэх жил 40 жилийнхээ ойгоогоо золгоно. Уурхайн нөөц бололцоо, түүхий эдийн чадавхи ер нь хэр байгаа бэ?

“Өнгөрсөн цаг хугацаандаа 39 жилийнхээ түүхийг бичиж, ирэх онд 40 жилийнхээ ойг тэмдэглэнгэдэг бол бид бүхний хувьд яах аргагүй бахархалтай үйл хэрэг. Хүний амьдралын бүхэл бүтэн нэгэн үе байна шүү дээ. Тухайн үедээ жилд 4-6 сая тонн нүүрс гаргах хүчин чадалтайгаар байгуулагдаж байсан. Одоогийн байдлаар жилдээ өнөөдрийн нүүрсний хэрэгцээг хангах зорилгын хүрээнд жилдээ хязгаарлагдмал байдлаар буюу 3.8-3.9 сая тонн олборлож байна.

Илүүт олборлох зорилго бий юу?

“Аливаа бизнес хэрэгцээ шаардлагад тулгуурладаг. Үүнийг дагаж ажиллаж байгаа маань энэ. Бид эрчим хүчний системд таарсан нүүрс нийлүүлдэг. Коксжих нүүрсний шаардлага манайд байхгүй учраас үүнээс илүүт борлуулах боломжгүй байгаа юм. Харин энэ жилдээ Хятадын зарим хэрэглэгчид манай нүүрсийг сонирхож эхэлж байна. Эрэн болон Бээжин хотын наад захын хотуудаас санал ирүүлсэн. Гэхдээ их хэмжээгээр буюу ойролцоогоор жилдээ таван сая тонн нүүрс авах санал тавьсан учраас хүчин чадалаа нэмэх болж байгаа юм. Одоогийн нөөц боломжоор бол хэцүү л дээ. Манай багийн хувьд 2017 онд ажил аваад нийгмийн сайн сайхан руу чиглэсэн аян зохион байгуулах, эко орчныг бүрдүүлэхэд нэлээн анхаарч ажиллаж байна. Үүний дагуу 100 мянган тонн сайжруулсан түлш боловсруулах үйлдвэр байгуулах төсөл бичсэн. Туслан гүйцэтгэгч компанитайгаа хамтарч, техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулсан. Үүнийгээ Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, техникийн зөвлөлд хүргүүлсэн. Харамсалтай нь, дөрөвдүгээр сард техник, эдийн засгийн үндэслэлээ өгсөн ч өнөөдрийг хүртэл харну нь гараагүй байна.

Яагаад тэр вэ?

Сайдын зөвлөлийн хурлыг хүлээж байгаа бололтой юм билээ. Гол нь, үүний ард бидний зүгээс цаг хугацаа алдаад байна. Хэрэв төсөл дэмжингдээд, хэрэгжүүлэх боломж нээгдчихвэл Улаанбаатар хотын жижиг хэрэглэгчдэд борлуулах боломжтой болно. Үндсэндээ манайх 380-400 мянган тонн



түүхий нүүрсийг Улаанбаатар хотын хэрэглэгчдэд борлуулдаг. Үүний 190 мянган тонныг нь утаагүй түлш болгоод гаргахад эргээд 300 мянган тонн түүхий нүүрс тэй тэнцэх хэмжээний утаагүй түлш, сайжруулсан нүүрс болж хэрэглэгчдэд очно. Энэ асуудал өнгөрсөн долоо хоногт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр яригдсан. Хөгжлийн банкинд хөрөнгө оруулалтыг нь яаралтай хийх асуудлаар чиглэл өгсөн. Мөн бидний зүгээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд төслөө өгсөн байгаа.

Хэр хэмжээний шаардлагатай байгаа вэ?

Хангалттай хэмнэлт хийгээд 22 орчим тэрбум төгрөгийн дэмжлэг хэрэгтэй. Ажлын байрны тухайд хуучин төмөр замд ашиглаж байсан том объект байгаа учраас тэндээ үйлдвэрлэлээ явуулахад бэлэн.

Хятадруу нүүрс борлууллаа гэхэд тээвэрлэлтэй холбоотой дэд бүтцийн асуудал хүндэрлэж шүү дээ. Үүнд ямар хариулт өгөх вэ?

Яг өнөөдөр тохиролцсон зүйл арга. Гэхдээ гаргалаа гэхэд төмөр замаар тээвэрлэнэ. Дараагийн шатанд манайд чанар муутай нүүрсний хаягдал их байдаг. Дунджаар 2100-2200 килокалорийн илчлэг багатай нүүрснүүд гэсэн үг л дээ. Иймд үүнийгээ баяжуулах замаар 1-1.5 дахин хувиар илчлэгийг нь нэмж зах зээлд борлуулах зорилго байна. Түүнийгээ станцууд хэрэглэгчдэд нийлүүлбэл нэмүү өртөг нэмж чадна. Энэ чиглэлээр Өмнөд

Солонгосын компани болон манай толгой компани болох “Эрдэнэс МГЛ”-ын зүгээс тус тусдаа санал тавьж, ярилцаж эхэлсэн байгаа. Жилдээ 1-1.5 сая тонн нүүрсийг хуурай аргаар баяжуулах замаар илчлэгийг нь сайжруулах тухай санал тэр хүрээнд яригдаж байна. Он гараад энэ дагуу Өмнөд Солонгос руу дээж явуулна. Мөн Япон руу элсний аргаар баяжуулдаг шинэ технологийн туршилт хийлгэх зорилгоор дээж явуулах манай байгаа. Гэхдээ элсний аргаар боловсруулах нь өндөр өртөгтэй учраас борлуултын үнэ өсч таараа. Иймд шууд хэрэглэхэд хэцүү гэж ойлгож болно. Хэрэв ашгаа бодох юм бол илчлэг нь бараг хоёр хувиар өсөх энэ аргыг сонгоход алдахгүй. Ямар ч байсан 40 жилийнхээ ойг утгаад утаагүй түлш боловсруулах, чанар муутай нүүрснийг илчлэгийг нэмүү өртөг шингээх замаар нэмэх гэсэн хоёр чиглэлээр шинэ үйлдвэр ашиглалтад оруулах зорилт тавин ажиллаж байна.

Сая уурхайгаар яваад машинистуудтай уулзахад алхагч эксковаторыг 20 жил ажиллах ёстой ч танайх 37 жил ажиллуулж байгаа тухай ярьж байна лээ. Энэ нь уурхай байгуулагдсан цагаас хойш ажиллуулсан гэдэг утгаар нь бахархаж болох ч үүнийг дагаад нэг эксковатор бус танай уурхайн бүх тоног төхөөрөмж, машин техник дээр яригдах насжилтын асуудал болгох юм билээ. Үүнтэй холбоотой зайшгүй шинэчлэх тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт

хугацаатай байдаг. Гол нь манайх өдөр, шөнөгүй ажиллуулдаг. Жолооч нь солигдохоос машин, техник нь солигддоггүй. Ээлж солигдох хоёр цагийн хугацаанд түр унтраахаас бусдаар хоногийн 22 цаг ажилладаг гэж бодохоор жил жилээр нь тооцоод үзэхээр ямар их хугацаа гарах нь ойлгомжтой. Жижиг эксковатор гэхэд 15 жил, алхагч эксковатор 20 жил ажиллах ёстой. Гэтэл манайх 37 жил ажиллуулж байх жишээний. Энэ нь зах зээлийн нийгэмд шилжихтэй зэрэгцээд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүй гэсэн үг. Цаашид бид бүхний хувьд энэ маягаар яваад байж болохгүй. Түр зуурын засвар үйлчилгээ хийх замаар аргааасаар байхад эргээд үйлдвэрлэлийн зардал асар өндөр болж ирж байна. Цаашид засварынхаа зардлыг даахгүй болж ирэхээр байгаа. Иймд хуучин эд ангийн сэргээх засварын төв байгуулахаар гурван тэрбум төгрөгийн төсөл бичсэн. Харамсалтай нь, толгой компаниас шууд дэмжихэд хэцүү байх шиг байна. Санхүүтэй холбоотой асуудал л даа.

Одоо өвөл ойртохтой хэрэгцэн нүүрсний нөөц хангалттай юу гэсэн асуудал яригддаг. Танай уурхай энэ асуудалд ямар хариулт өгөх вэ?

Өнөөдөр гэхэд авахад бэлэн, усан дээрх нүүрс 611 мянган тонн бий. Усан доор 50 мянган тонн байгаа. Өвлийн ид ачааллын үед хоёр сар манай уурхай зогсолт хийгээд ачихад асуудалгүй гэсэн үг.

Хугацаатай байдаг. Гол нь манайх өдөр, шөнөгүй ажиллуулдаг. Жолооч нь солигдохоос машин, техник нь солигддоггүй. Ээлж солигдох хоёр цагийн хугацаанд түр унтраахаас бусдаар хоногийн 22 цаг ажилладаг гэж бодохоор жил жилээр нь тооцоод үзэхээр ямар их хугацаа гарах нь ойлгомжтой. Жижиг эксковатор гэхэд 15 жил, алхагч эксковатор 20 жил ажиллах ёстой. Гэтэл манайх 37 жил ажиллуулж байх жишээний. Энэ нь зах зээлийн нийгэмд шилжихтэй зэрэгцээд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүй гэсэн үг. Цаашид бид бүхний хувьд энэ маягаар яваад байж болохгүй. Түр зуурын засвар үйлчилгээ хийх замаар аргааасаар байхад эргээд үйлдвэрлэлийн зардал асар өндөр болж ирж байна. Цаашид засварынхаа зардлыг даахгүй болж ирэхээр байгаа. Иймд хуучин эд ангийн сэргээх засварын төв байгуулахаар гурван тэрбум төгрөгийн төсөл бичсэн. Харамсалтай нь, толгой компаниас шууд дэмжихэд хэцүү байх шиг байна. Санхүүтэй холбоотой асуудал л даа.

Одоо өвөл ойртохтой хэрэгцэн нүүрсний нөөц хангалттай юу гэсэн асуудал яригддаг. Танай уурхай энэ асуудалд ямар хариулт өгөх вэ?

Өнөөдөр гэхэд авахад бэлэн, усан дээрх нүүрс 611 мянган тонн бий. Усан доор 50 мянган тонн байгаа. Өвлийн ид ачааллын үед хоёр сар манай уурхай зогсолт хийгээд ачихад асуудалгүй гэсэн үг.

## 60 сая төгрөгийн хадлангийн техник тоног төхөөрөмжийг хүлээлгэж өгөв

ХХААХҮЯ-ны харьяа Малын удмын сангийн үндэсний төвд НҮБ-ын ХХААБ-аас өчигдөр 60 сая төгрөгийн үнэ бүхий хадлангийн техник, тоног төхөөрөмжийг гардуулан өглөө. “Тан, зуд хавсарсан хүндрэлд яаралтай тусламж үзүүлэх, даван туулах чадварыг бэхжүүлэх” техник, хамтын ажиллагааны ТСР/МОН/3602 төслийн дэмжлэгтэйгээр нийлүүлэгдэж буй техник, тоног төхөөрөмжийг гардуулах үйл ажиллагаанд ХХААХҮЯ-ны харьяа Малын удмын сангийн үндэсний төвийн Үйлдвэр технологийн албаны дарга Я.Оюунбилэг, НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч Аднан Куэрэши болон бусад албаны төлөөлөл оролцлоо. ХХААХҮЯ-ны харьяа Малын удмын сангийн үндэсний төвийн Үйлдвэр технологийн албаны дарга Я.Оюунбилэг “Бид энэ төхөөрөмжүүдээ аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж хадлангаа бэлтгэнэ. ХХААХҮЯ 2008 оноос эхлэн НҮБ-ын Хөдөө аж ахуйн байгууллагатай хамтын ажиллагаатай ажиллаж байгаа. Цаашид ч олон ажлыг хамтдаа хийнэ гэж итгэж байна. Монголын мал аж ахуй, газар тариалангийн салбарт хэрэгжсэн олон төсөл хөтөлбөрийн үр шимийг малчид, тариаланчид хүртсээр ирсэн. Жишээлбэл, бидний хамгийн эхний төсөл бол “Сүүний үхрийн удам зүй, гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийн сан” байлаа. Мөн энэ төслийн хүрээнд Малын удмын сангийн Үндэсний төвд үр үйлдвэрлэлийн бага оврын лабораторийн тоног төхөөрөмжийг суурилуулж өгсөн. Үүний үр дүнд 2008 оноос хойш өнөөг хүртэл Монголд үржүүлж байгаа шилмэл малын хээлтүүлэгчээс үр үржүүлж авах ажлыг хийж байна. Энэ мэтчилэн хамтын ажиллагааны үр өгөөж өндөр байна. Монголын мал аж ахуйг хөгжүүлж, чанарыг сайжруулахад байнга дэмжлэг үзүүлж хамтарч ажилладаг НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагад талархаж байгаагаа ирэхийг хүсье” гэв. НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч Аднан Куэрэши энэ үеэр “ХХААХҮЯ-ны харьяа Малын удмын сангийн үндэсний төвд хадлангийн тоног төхөөрөмж болох бага оврын трактор, хадлангийн агрегат чиргүүлийн хамт, өвс хаман боогч, гар хаддуур, жижиг усалгааны систем зэргийг нийлүүлж байна. Энэ нь өвөлжилт хүндрэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлтгэл ажлыг хангахад зориулан өгч байгаа тусламж юм. Манай НҮБ-ын ХХААБ-аас 2.6 сая ам долларын хүмүүнлэгийн тусламжийг 10 мянга гаруй малчин өрх туслах болон малын гоц халдварт өвчинтэй тэмцэхэд зарцуулсан” гэдгийг онцлов.

Хугацаатай байдаг. Гол нь манайх өдөр, шөнөгүй ажиллуулдаг. Жолооч нь солигдохоос машин, техник нь солигддоггүй. Ээлж солигдох хоёр цагийн хугацаанд түр унтраахаас бусдаар хоногийн 22 цаг ажилладаг гэж бодохоор жил жилээр нь тооцоод үзэхээр ямар их хугацаа гарах нь ойлгомжтой. Жижиг эксковатор гэхэд 15 жил, алхагч эксковатор 20 жил ажиллах ёстой. Гэтэл манайх 37 жил ажиллуулж байх жишээний. Энэ нь зах зээлийн нийгэмд шилжихтэй зэрэгцээд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүй гэсэн үг. Цаашид бид бүхний хувьд энэ маягаар яваад байж болохгүй. Түр зуурын засвар үйлчилгээ хийх замаар аргааасаар байхад эргээд үйлдвэрлэлийн зардал асар өндөр болж ирж байна. Цаашид засварынхаа зардлыг даахгүй болж ирэхээр байгаа. Иймд хуучин эд ангийн сэргээх засварын төв байгуулахаар гурван тэрбум төгрөгийн төсөл бичсэн. Харамсалтай нь, толгой компаниас шууд дэмжихэд хэцүү байх шиг байна. Санхүүтэй холбоотой асуудал л даа.

Одоо өвөл ойртохтой хэрэгцэн нүүрсний нөөц хангалттай юу гэсэн асуудал яригддаг. Танай уурхай энэ асуудалд ямар хариулт өгөх вэ?

Өнөөдөр гэхэд авахад бэлэн, усан дээрх нүүрс 611 мянган тонн бий. Усан доор 50 мянган тонн байгаа. Өвлийн ид ачааллын үед хоёр сар манай уурхай зогсолт хийгээд ачихад асуудалгүй гэсэн үг.

## АН-ын Зүүн бүсийн чуулга уулзалт боллоо

“Намын шинэчлэлээс Монголын шинэчлэл” уриан дор Ардчилсан намын Зүүн бүсийн чуулга уулзалт боллоо. Их эзэн Чингис хааны өлгий нутаг Хэнтий аймгийн Биндэр сум, Онон Хурхын бэлчирт Ардчилсан намын зүүн бүсийн чуулга уулзалт энэ сарын 12, 13-ны өдрүүдэд болж өндөрлөлөө. Чуулганы гол зорилго нь нам шинэчлэгдэж байгаатай холбоотойгоор намын гишүүн бүрийн оролцоог дээшлүүлэх, нийслэл орон нутгийн намыг харилцан уялдаа холбоотой ажиллуулах, туршлага солилцох гэх зэрэг олон талт чадварыг сайруулах байв. Мөн тэр бүр нийслэлд болж байгаа намын болон улс төрийн арга хэмжээнд ирж оролцох боломжгүй гишүүдэд намын бодлого, цаашдын зорилгоо танилцуулснаараа онцлог болов. Чуулганд АН-ын дарга С.Эрдэнэ, УИХ дахь АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат, УИХ-ын гишүүн



Ж.Батзандан, УИХ-ын гишүүн Д.Мурат, УИХ-ын гишүүн асан Б.Гарамгайбаатар, АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Туваан, АН-ын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Үүрийнтуяа, мэргэжлийн сумогийн 68 дахь их аварга Асашёорюу Д.Дагвадорж болон нийслэл, орон нутгийн 700 гаруй төлөөлөгч оролцсон юм. Чуулганы үеэр Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаархи асуудлыг УИХ дахь АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат, АН-ын хууль, эрх зүйн газрын дарга Б.Батхуяг, хуульч Д.Оросоо, нийслэлийн АН-ын дэд дарга А.Цэрэнбат нар хөндөж, бодлогын хэлэлцүүлэг,

сургалт зохион байгууллаа. Мөн УИХ дахь АН-ын бүлгийн гишүүд УИХ-ын хаврын чуулганы үеэр хийсэн ажлынхаа талаар намынхаа гишүүдэд мэдээлэл өгсөн юм. Түүнчлэн намын гишүүдийнхээ идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бодлогын сургалтуудыг зохион байгуулахаас гадна гар бөмбөг, хөл бөмбөг, Эх орон-36 буухна тэмцээн, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулж, байгалийн гамшиг болон гал түймрийн үеэр гэр оронгүй болсон нутгийн гурван өрхөд таван ханатай өргөө цагаан гэр бэлэглэх сайн үйлсийн аяныг зохион байгууллаа.

## “НОГООН ЭДИЙН ЗАСАГ БИДНИЙ АМЬДРАЛД” гэрэл зургийн уралдаан зарлагдаа

Бид таныг НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (PAGE)-ээс зарлаж буй “Ногоон эдийн засаг бидний амьдралд” гэрэл зургийн уралдаанд оролцохыг урьж байна. Ногоон хөгжлийн сэдвийн хүрээнд байгальд ээлтэй, ногоон ажил хөдөлмөр эрхлэлт, ногоон дэд бүтэц /тухайлбал сэргээгдэх эрчим хүч/, ногоон амьдралын хэв маяг, хэрэглээ, байгаль орчин, экосистемийг хамгаалах үйлс, ногоон эдийн засгийн мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээж буй үйлс зэрэг өөр өөр газар, байршил, нөхцөлд авсан, сонирхолтой зургуудыг илгээж, уралдаанд оролцох боломжтой. Гэрэл зургийн уралдаанд оролцогч 3 хүртэл зураг илгээж болно. Уралдаанд 18 нас хүрсэн, Монгол Улсад оршин сууж, амьдарч буй аль ч улсын иргэн оролцож болно.

- Зургийг илгээх
• Уралдаанд оролцох албан ёсны маягтыг бөглөж, дижитал зургаа оруулна. Албан ёсны маягтыг бөглөснөөр уралдааны дүрэм журам, нөхцөл, зургийг ашиглах, оюуны өмчийн эрхтэй холбоотой бүхий л асуудлыг хүлээн зөвшөөрч буй хэрэг юм.
• Зураг бүр нь зургийн нэр, зургийг авсан огноо, байршил, тайлбар /100 хүртэл үгтэй/ зэрэг мэдээлэлтэй байна.
• Гэрэл зураг нь JPEG форматтай байна.
• Оролцогчийн зураг өөрийн авсан оригинал зураг байх ба 8 Mega pixels багагүй байна.
• Зураг нь хар/цагаан, өнгөт, хөндлөн ба босоо хэлбэртэй байж болно.
Уралдааны шагнал
• 1-р байр (1): Хүндэт өргөмжлөл, 1,000,000 төгрөг
• 2-р байр (2): Хүндэт өргөмжлөл, тус бүр 800,000 төгрөг
• 3-р байр (3): Хүндэт өргөмжлөл, тус бүр 500,000 төгрөг.
• Шагналт байранд орсон зурагчид (10 зураг) БОАЖЯ, НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийн Хүндэт өргөмжлөлийг гардуулна.

Зураг илгээх эцсийн хугацаа: 2017 оны 9-р сарын 4-ний шөнийн 12:00 цаг (ULAT/GMT+8)
Уралдааны удирдамжтай танилцах, зураг илгээх: http://www.un-page.org/photos
Уралдааны дүнг мэдэгдэх: 2017 оны 9-р сарын 11-ний өдөр
Нэмэлт мэдээллийг pagemongolia@gmail.com цахил иууданаар хандаж авна уу.

# ДЭЛХИЙ

## Д.ТРАМПЫН МЭДЭГДЛЭЭС ҮҮДЭЖ, ЗӨВЛӨЛИЙН ТАВАН ГИШҮҮН ОГЦОРЛОО



### Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Тус мөргөлдөөний талаар Ерөнхийлөгч Д.Трамп өөрийн байр сууриа илэрхийлсэн хэдий ч, бөөрөнхийлсөн маягтай үг хэлсэн нь олны дургүйцлийг төрүүлээд байсан. Харин Ричард Трумка түүний хэлсэн үгийг “сохор үзэл, дотоодын терроризм”-ыг хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлсэнээс ялгаагүй хэмээн шүүмжилсэн байна. Ингэснээр тэрбээр Д.Трампыг Ерөнхийлөгч болсноос хойш огцорсон зөвлөлийн тав дахь хүн болж байгаа юм.

Ричард Трумка мэдэгдэлдээ “Сохор үзэл, дотоодын терроризмыг хүлээн зөвшөөрч буй мэт аяглаж байгаа Ерөнхийлөгчийн төлөө ажиллаж чадахгүй нь” хэмээн дурьдаж, албан тушаалаасаа огцорч буйгаа зарласан байна. Тэгвэл мөн өдөр Ерөнхийлөгч Трампаас Чарлоттесвиллд гарсан мөргөлдөөний талаар сэтгүүлч асуухад “Хоёр тал хоёулаа л буруутай” гэж хариул-

сан аж. Үүнээс өмнө АНУ-ын Төрийн тэргүүний байгуулсан Аж үйлдвэрийн зөвлөлийн үйлдвэрчний эвлэлийн дарга Скотт Пол ч гэсэн өөрийн хүсэлтээр огцорч буйгаа мэдэгдсэн юм. Түүнчлэн, эм үйлдвэрлэлийн аварга компани “Мерск”-ийн гүйцэтгэх захирал Кэн Фрэзер, спорт хувцас хэрэглэлийн “Under Armour”-ын CEO Кэвин Планк, “Интел” компанийн CEO Брайн Крзанич нар ч гэсэн огцрохоо мэдэгдээд байна. “Мерск”-ийн гүйцэтгэх захирал Кэн Фрэзер Африк гаралтай америк хүн билээ.

АНУ-ын Виржиниа мужийн Шарлоттесвиллд энэ сарын 12-нд үндсэрхэг үзэлт цагаан арьстнууд болон тэднийг эсэргүүцэгчдийн хооронд мөргөлдөөн гарсны улмаас нэг хүн амь үрэгдэж, хэдэн арван хүн гэмтэж бэртсэн юм. Мөргөлдөөн гарсны дараа Ерөнхийлөгч Д.Трамп анхны мэдэгдэлдээ үндсэрхэг үзэлт цагаан арьстнуудыг буруутгахаас зайлсхийсэн нь олны эсэргүүцэлтэй тулгарсан юм.

### Сьерра Леонд 300 гаруй хүн нас барлаа

Баруун Африкийн Сьерра Леонд хэдэн өдөр үргэлжлэн орсон борооны улмаас үер, хөрсний нуралтын гамшиг нүүрлэж, эдүгээр хүртэл 300 гаруйхун нас барж, олон зуун хүн ор сураггүй болсон байна. Сураггүй болсон иргэдийн тоо хараахан тодорхойгүй байгаа ч, Улаан загалмайн хавирган сар нийгэмлэг 600-г давсан гэж хэвлэлд мэдээлсэн байна. Одоогоор гамшигын бүсэд цагдаа, цэргийнхэн ажиллаж, шороонд дарагдсан хүмүүсийг аврахаар ажиллаж байгаа ч, техникийн хучин чадал дутагдаж байгаа гэнэ. Цаашид ч гамшигийн хохирлын хэмжээ нэмэгдэж болзошгүй учраас тус улсын Засгийн газар онц байдал зарлаж, олон улсын нийгэмлэгээс эм тариа, хоол сурвалжийн “NHK” агентлагт

мэдээлснээр өнөөдрийг хүртэл 300 гаруй хүн нас барсан нь тогтоогдсоны 100 нь бага насны хүүхэд байжээ. Мөн олон хүн ор сураггүй болсон байна. Сураггүй болсон иргэдийн тоо хараахан тодорхойгүй байгаа ч, Улаан загалмайн хавирган сар нийгэмлэг 600-г давсан гэж хэвлэлд мэдээлсэн байна. Одоогоор гамшигын бүсэд цагдаа, цэргийнхэн ажиллаж, шороонд дарагдсан хүмүүсийг аврахаар ажиллаж байгаа ч, техникийн хучин чадал дутагдаж байгаа гэнэ. Цаашид ч гамшигийн хохирлын хэмжээ нэмэгдэж болзошгүй учраас тус улсын Засгийн газар онц байдал зарлаж, олон улсын нийгэмлэгээс эм тариа, хоол сурвалжийн “NHK” агентлагт

### Дүрвэгсдийн лагерт террорист халдлага болжээ



Баруун Африкийн Нигерт лалын хэт даврагч Боко Харам бүлэглэл цуврал террорист халдлага үйлдэж, 27 хүн нас барж, 83 хүн гэмтэж бэртжээ. Нигерийн зүүн хойд этгээдийн Борно мужийн төв Майдугури хотын зах зээл болон ойролцоох дүрвэгсдийн лагерийн орох хаалганы орчимд гурван эмэгтэй биедээ тэсрэх бодис бүслэн амиа золиослосон байна. Албаны хүмүүсийн мэдээлснээр, гурван цэгт дэлбэрэлт болж, хамгийн багаар бодоход 27 хүн нас баржээ. Террорист халдлага нэг цагт дараалан болсон бөгөөд аюулгүйн албаныхан Нигерийн зүүн хойд этгээдийг хяналтдаа авч үйл ажиллагаа явуулдаг

Боко Харам бүлэглэл зохион байгуулсан байж болзошгүй хэмээн таамаглаж, шалгалтын ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Хэт даврагч “Лалын улс” бүлэглэлд үнэнч байхаа тангаргалсан Боко Харам бүлэглэл энэ онд Нигерийн Засгийн газраас явуулсан цэргийн тусгай ажиллагааны улмаас эзэмшил нутгаа алдсан билээ. Гэтэл тус ажиллагааны хариу болгож, гэм зэмгүй хотын иргэд рүү чиглэсэн террорист халдлага удаа дараа зохион байгуулах болсон юм. Ингэхдээ ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүдэд тэсрэх бөмбөг бүхий бүс зүүлгэн террорист халдлагаадаа ашиглах болсон байна.

### “Филиппинийн хамгийн их цус асгарсан шөнө”

Филиппиний цагдаа нар энэ сарын 14-15-нд шилжих шөнө Ерөнхийлөгч Родриго Дутергийн санаачилсан “Хар тамхины бүлэглэлийн эсрэг дайн”-ы хүрээнд нийслэл Манила хотын орчимд тусгай ажиллагаа явуулж, 32 хүний аминд хүрчээ. Энэ нь тус улс хар тамхины эсрэг дайн зарласнаас хойш цагдаа нар нэг шөнийн дотор хамгийн олон хүний аминд хүрсэн тохиолдол болж байна. Цагдаа нар Нийслэл Манила хотоос

хойд зүгт орших Булакан мужийн 12 хот, тосгодын нийтдээ 26 цэгт тусгай ажиллагаа явуулжээ. Харин амиа алдсан 21 иргэн гартаа зэвсэгтэй, эсэргүүцэл үзүүлсэн тул хөнөөсөн гэж цагдаагийнхан тайлбарлаж байна. Мөн 64 хүнийг баривчилж, 21 зэвсэг, 100 гр хар тамхи хураажээ. Филиппиний Ерөнхийлөгч Родриго Дутерте 2016 онд хар тамхины эсрэг дайн зарласнаас хойш тус улсын цагдаа нар хар

тамхи хэрэглэдэг болон худалддаг хэдэн мянган хүнийг ажиллагааны явцад буудан устгаад байгаа юм. Мансууруулах бодисын наймааг таслан зогсоох зорилго бүхий энэ кампанит ажлын явцад сэжигтнүүдийг гэм буруутай нь тогтоогдоогүй байхад шууд буудан хөнөөж байгааг дэлхий нийтээрээ шүүмжилж, зэмлэн буруушаасаар байгаа билээ. Ажиллагааны үеэр мөн 100 гаруй хүнийг баривчилжээ.

### МН370 онгоц Энэтхэгийн далайн өмнөд эрэгт живсэн байх магадлалтай гэв

Гурван жилийн өмнө сураггүй алга болсон Малайзын иргэний агаарын тээврийн МН370 онгоц Энэтхэгийн далайн өмнөд эргийн орчимд живсэн байх магадлал өндөр хэмээн Австралийн Засгийн газраас мэдээллээ. Тэд хиймэл дагуулын бичлэгт үндэслэн энэхүү таамгийг хийсэн байна. Нисэх багийн болон зорчигчид нийлсэн 239 хүн тээвэрлэж явсан МН370 нислэгийн дугаартай онгоц гурван жилийн өмнө Өмнөд Хятадын тэнгис дээгүүр нисч явахдаа радарын дэлгэцээс алга болсон юм. Мэргэжилтнүүд онгоцыг Энэтхэгийн далайд сүйрсэн гэж үзэж байгаа билээ. Түүнээс хойш хөлгийг хайх ажиллагаа эхэлсэн ч, төдийлөн үр дүнд хүрч чадаагүй тул энэ оны нэгдүгээр сард хайгуулын ажлыг зогсоосон. Гэхдээ Австралийн Тээврийн аюулгүй байдлын захиргаа түүнээс хойш ч мэргэжилтнүүдэд илгээн улс бүрийн хиймэл дагуулын бичлэгт дүн шинжилгээ хийж байжээ. Улмаар тус шинжилгээнийхээ дүнг өчигдөр олон нийтэд мэдээллээ. Мэдэгдэлд дурьдсанаар, онгоцны үлдэгдэл одоогоор Энэтхэгийн далайн өмнөд хэсэгт живсэн байх магадлал өндөр байгаа юм байна. Ингэхдээ дэлхийн бөмбөрцгийн өмнөд өргөргийн 35 градус зургаан минут, зүүн уртрагийн 92 градус найман минут буюу 5000 хавтгай км-ыг хамарсан талбайд байх магадлалтай аж. Өнөөдрийг хүртэл тус талбайд нэг ч хайгуул хийгдээгүй байжээ. Гэхдээ Австралийн албаныхан эрлийг дахин эхлүүлэх эсэх нь тодорхойгүй байна.

### ОХУ Пхеньянд пуужингийн хөдөлгүүр нийлүүлсэн үү

Украин улсад үйлдвэрлэсэн пуужингийн хөдөлгүүрийг ОХУ Умард Солонгост нийлүүлсэн байх магадлалтай гэж тус улсын төрийн сансар судлалын агентлагийн удирдах зөвлөлийн тэргүүн таамаглажээ. Тус агентлагийн удирдах зөвлөлийн тэргүүн Юрий Радченко Умард Солонгосын пуужингийн хөтөлбөрийг судалж буй тухай мэдээлэл өгөхдөө мягмар гарагт ийнхүү мэдэгджээ. Пхеньяны “Хвасонг-14” баллистик пуужинд хэрэглэсэн хөдөлгүүр нь хуучин Зөвлөлтийн үеийн хөдөлгүүрийг засч сайжруулсан хувилбар гэж АНУ-ын мэргэжилтнүүд тайландаа дурьдсан байдаг. Майкл Эллеманы гаргасан Стратеги судалгааны олон улсын институтын тайланд Умард Солонгосын тив хоорондын баллистик пуужингийн технологи маш хурдацтай

хөгжсөн шалтгаан нь Украинд үйлдвэрлэсэн хуучин Зөвлөлтийн хөдөлгүүртэй холбоотой гэжээ. Тус хөдөлгүүрийг хар захаас худалдан авсан байх магадлалтай аж. М.Эллеманы тайлан хэвлэгдсэний дараа хийсэн хэвлэлийн бага хурлын үеэр Ю.Радченко Умард Солонгосын пуужинд хэрэглэсэн хөдөлгүүр нь 2001 оныг хүртэл Украинд үйлдвэрлэсэн хөдөлгүүр гэж мэдээлжээ. Эдгээр хөдөлгүүрийг ОХУ-д нийлүүлдэг байжээ. Мөн тэрбээр ОХУ, Умард Солонгосын найрсаг харилцааны үр дүнд Москва-Пхеньяныг пуужин болон хөдөлгүүрээр хангасан байх гэж хэлсэн юм. ОХУ-ын Шадар сайд Дмитрий Рогозин, Умард Солонгос Украины мэргэжилтнүүдийн тусламжгүйгээр хөдөлгүүр үйлдвэрлэх ямар ч боломжгүй гэж тэдний тайланд хариу өгчээ.



### Египетээс 2000 жилийн өмнөх гурван булш олджээ

Археологичид Египетийн өмнөд нутгаас 2000 жилийн тэртээд хамаарах гурван булш олж илрүүлжээ. Булшнуудыг нийслэл Каир хотоос өмнө зүгт орших Миня мужийн Аль-Камин аль-Сахрани гэдэг газар хийсэн малтлагын үеэр гаргаж ирсэн байна. Археологичдын багийн ахлагч Али Аль-Бакру хэлэхдээ “Нэг булшинд нь эрэгтэй, эмэгтэй хүн болон өөр өөр насны хүүхдүүдийн яс байна” гэв. Судлаачдын үзэж буйгаар, эдгээр булш нь томоохон хотын оршуулгын газрын нэг хэсэг байж магадгүй. Тус улсын Эртний үнэт дурсгалууд судлалын яамнаас гаргасан мэдэгдэлд “Малтлагын ажил үргэлжилж байна. Археологичид илүү олон нууцыг тайлахаар ажиллаж байна” гэжээ. Энэ газарт 2015 оноос малтлага хийж эхэлсэн гэнэ. Гурван булш МЭӨ 525 оны Египетийн 27 дахь эзэн хааны үеэс Греко Романы үеийн олдвор болохыг нь тогтоожээ.

## ЧУХАЛ ХҮН



Н.Цэцэгмаа Монголын эргэцүүлгүүдийн хоёгчийн нийгэмлэгийн тэргүүн, зохиолч, яруу найрагч Ж.Цогтсугар багийнхнаа халт

# Н.ЦЭЦЭГМАА: ЭРЧҮҮДЭД УРМЫН ҮГ

Г.ГАНЧИМЭГ

Архийг зарим хүн идээний дээж хэмээн хүндэтгэдэг бол нөгөө нэг нь чөтгөрийн ундаа гээд нэг нүдээрээ ч үзэхгүй. Алтан наран алаггүй ч аавын хөвгүүд адилгүй учир архинд хандах хандлага нь бас ондоо. Ёс учраас ёроолыг нь гаргаж, дуртайдаа духандаа хүргэн дугтарсаар архичин гэдэн "ажил"-тай болсон нь ч цөөнгүй. Амьдралдаа ийн алдаж эндэж яваа нэгнийг эхийн сэтгэлээр тосч аваад чадахаасаа чадахгүйгээ хүртэл араас нь дагаж, өөрөөс нь түшихээр сэтгэл шулуудсан нэгэн сайхан багшийг бид "Чухал хүн" булангийнхаа зочин хойморьт урьсан юм. Түүнийг зарим нь багш аа хэмээн хүндэтгэн дууддаг бол зарим нь ээж ээ хэмээн "эрхэлнэ". ШШГЕГ-ын харьяа Согтууран мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын сургагч багш Ноосойн Цэцэгмаатай доорх яриаг өрнүүлээ.

Өөрийгөө хайрлаж байгаа хүн архи уухгүй шүү дээ. Миний энэ сургалтаас гадна төрх зан үйлийн хичээл ордог хоёр сэтгэлзүйч байгаа. Тэд "Ахиж дэвших 12 алхам"-ыг заадаг юм. Мөн нийгмийн ажиглан гээд дөрвөн хүний хүч хөдөлмөр, гараар дамжиж байж эм тарнагаар л асуудлыг шийдэх биш сэтгэл зүйгээрээ хүн бодол санаагаа өөрчилдөг. Хүний тархи оюунтай ноцолдож, дотоод сэтгэлийг нь уудлаад ирэхээр тэр хүний мэдрэмж аяндаа өөрчлөгдөж байгаа нь анзаарагддаг. Би үүнийг долоон жилийн турш явуулсан сургалтаасаа ажиглаж байна. Зөвхөн ийм сургалтаар архинаас гарсан олон хүн бий. Үр дүн гарч, архинаас гарсан хүмүүс янз бүрийн салбарт ажиллаж байна. Зарим нь бүр БНСУ-д хүний зэрэгтэй ажиллаж

хүмүүстэй ажилладаг. Энэ бол хүнд хөдөлмөр. Монголд ганцхан байгаа байгууллага. Гэхдээ манай байгууллагын нөхцөл бололцоо ч их сайжирсан. Бүх өрөөндөө засвар хийж, эмч сувиллагч нар маань бүрэн бүрэлдэхүүнээрээ энэ хүмүүсийн төлөө нойр, хоолгүйжиллаж байна. Манай байгууллагын ажилтнууд их мундаг. Сувиллагч нь сувиллагчаа, эмч нь эмчийнхээ ажлыг хийдэггүй. Бүгдээрээ л энэ хүмүүсийн тархи оюунтай ноцолдож, нийгмийн ажиглан болгоосон. Аймгууд ч манай байгууллага руу хүнээ их чиглүүлж байгаа. Харамсалтай нь зарим нэг орон гэргүй, очих хань ижилгүй хүмүүс гарч ирээд л дахиад архна уучих гээд байдаг. Үүн дээр зарим аймаг их мундаг зохион байгуулалт хийсэн. Тухайлбал, Өмнөговь аймгийг нэр дурдаж болно. Тус аймгийн сүмийнхэн очих орон гэргүй, хань ижилгүй хүмүүсийг сүмийнхээ дэргэд авч амьдрах орон байраар хангаж байх жишээний. Мөн Хэнтий аймгийн Засаг дарга асан Ж.Оюунбаатар архигүй Хэнтийн төлөө маш сайн ажилласан.

**-Таны ажлын хамгийн бахархалтай хэсэг нь хэзээ байдаг бол?**

Өвчтнүүд маань бүх сургалтаа дуусгасны дараа би өөрчлөгдсөн шүү гэдгээ илэрхийлж "Эдгэрлийн баяр"-ыг хийдэг. Манай Нийгэм, сэтгэлзүйн алба энэ арга хэмжээг зохион байгуулдаг юм. Түүн дээр чин сэтгэлийн үгээ хэлж байгаа хүмүүсийг хараад бидний ажлын үр дүн юм даа л гэж боддог. Шавь нар, хүүхдүүд минь үнэхээр мундаг, бахархаггүй байхын аргагүй байдаг шүү.

**-Та түрүүнд шавь нар маань байнга эргэх холбоотой байж, утсаар ярьдаг гэж байсан?**

Тийм ээ. Эмч ээ, миний биед тийм өөрчлөлт өгөөд байна. Одоо яах вэ. Багш аа би таныхаа зааж сургаснаар сайн явж байгаа шүү гээд тулгамдсан асуудал, сэтгэлийн үгээ хэлж, өөр хоорондоо ярьж зөвлөдөг юм. Сувиллагч, сэтгэлзүйч, нийгмийн ажиглан ер нь бүгдтэй нь энэ мэтээр залгаад ярихад нээлттэй. Зарим нь "Энэ ч хүүгээ сайхан болгочих юмсан", "Тэр ч дүүгээ архинаас гаргачих юмсан" гээд дагуулаад ирдэг. Энд ирж өөрийгөө эмчлүүлсэн хүн эргээд найзгаа эсвэл хамаатныхаа хүнийг дагуулаад ирдэг шүү. Өөрөө архинаас гарсан хүн "Энэ миний жинхэнэ найз байгаа юм. Ээж аавыгаа өнгөрсөнөөс хойш жаахан гундаад байна. Найзыг маань архинаас ангижруулж өгөөч" гэдэг хүсэлт тээгээд

-Ажиглаад байхад та фэйсбүүктэй их нөхөрлөдөг бололтой. Гэхдээ дийлэнх пост нь цаанаа л нэг сургамжилсан онго аястай юм. Олон шавьтай хүн арга ч үгүй биз.

-Өө, биончүгсийг их маягийн тавина шүү дээ. Сэтгэлийн дэм өгч, урам хайрласан үгэнд хүн их баярладаг. Авах хүнд үг ганцдахгүй. Ер нь үг хүнийг амьдруулж, бас үхүүлэх шидтэй шүү дээ. Гэхдээ би "Аав хүнийг уурлуулбал Алтайн уулс нурах мэт, ээж хүнийг гомдоовол эхтэй булаг ширгэх мэт" гэхчилэнгээр дандаа хүнд ухаарал хайрлаж, нэгийг бодогдуулсан онч үгсийг их тавьдаг. Фэйсбүүк хол байгааг нь дэргэд байгаа юм шиг уулзуулж, ганцаараа байгаа нөгөөд бол сэтгэлийн хань юм даа.

**-Таны шавь нар аймаг болгонд бий байх. Удахгүй шавь нар чинь цугларна гэж сонссон?**

Миний багш зохиолч, яруу найрагч Ж.Цогтсугар. Багш маань "Монголчууд архинаас татгалзаж байна" нэвтрүүлгийг хөтөлдөг. Энэ сарын 19-нд "Багшаа алдаршуулъя" цэнгүүнийг багш маань ШШГЕГ-ийн "Төр хур" амралт сувилалд зохион байгуулах гэж байгаа юм. Монгол Улсын 18 аймаг, гурван том хотоос ирсэн хүмүүс ширхэг ч архины шилгүй их гоё арга хэмжээг зохион байгуулна гээд төсөөлөөд үз дээ. Тэд маань согтууруулах ундаанаас ямар ч хамааралгүй болсон хүмүүс.

**-Ёстой мундаг юм аа. Гэхдээ яаж. Айл гэрт архи уудаг ганц хүн байхад л ямар хэцүү, хүндрэлтэй байдаг билээ. Гэтэл тийм олон хүнийг архинд донтох өвчнөөс нь салгаж чадсан**

гэхээр нэг л санаанд багтахгүй юм. Магадгүй зарим нь бүр итгэхгүй байх л даа. Ямар гэцийн нууц жор хэрэглэх вэ?

-Хамгийн гол нь хүнтэй ажиллах арга эвээ л сайн олох юм уу даа. **-Ингэхэд та яагаад заавал архинд донгсон хүмүүстэй "ноцолдсон" юм бэ. Таны чин сэтгэлийн угаас хийхийг хүсч байсан ажил уу. Эсвэл цэрэгжилттэй газрын жишгээр даргын тушаалыг л үг дуугүй дагав уу?**

-Эгч нь ШШГЕГ-ын харьяа Согтууран мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар ажилладаг. 2010 онд би Тамхи, архинаас шалтгаантай эмгэг өвчин судлалын төв болон Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс хамтран зохион байгуулсан сургалтад суусан юм. Ер нь манай байгууллага, хамт олон ерөөсөө л хүний төлөө байдаг. Та эмчлүүлэгч, байгууллага хоёрын хооронд гүүр болж чадах хүн гэж хэлээд намайг сургалтад суулгахаар явуулсан. Түүнээс хойш хамт оныхоо хүлээлгэсэн итгэлийг алдахгүй үүргээ биелүүлэхийг хичээсээр, архины хамааралтай хүмүүст "Сэтгэл зүй, оюун санааны есон дэвшил" хөтөлбөр сургалтыг явуулсаар байна.

**-Амьдрал дээр архинд донгсон хүн үүнийг хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй юм шиг ээ. "Би архичин биш" гээд л агсам тавиад байдаг шүү дээ?**

-Архинд донтох өвчнөө эмчлүүлж буй хүн маань 14 хоногийн турш дотоод жарманд баригдаж амьдрагч. Халуун усанд орж, цагаан хэрэглэлтэй оронд унтана.

...Эрчүүдэд маань жаахан сэтгэлийн дэм, урмын үг хэрэгтэй. Ний нуугүй хэлэхэд, зарим эмэгтэй хүн хэтэрхий их би-гээр өвчилчихсэн байна. Би л энэ амьдралыг авч явж байна. Би л их мөнгө олж байна. Чи юу чадааг юм. Хэзээ юу олж ирж байсан юм гэх мэтээр. Энэ чинь эргээд эр хүний үнэт чанарыг алдагдуулж байна гэх үү дээ...

Амарч тайвшрахаараа арай ондоо болно. Түүнээс биш анх ирэхдээ маш их үгүйсгэлтэй ирдэг. Цагдаа, ар гэрээ харааж зүхэн, хашгичсаар орж ирнэ. Өөрийгөө архинд донтох өвчтэй болсон байна гэдгээ ойлгож мэдэхгүй, огтхон ч хүлээн зөвшөөрөхгүй шүү дээ. За тэгээд хамгийн эхний арга хэмжээ нь "Сэтгэл зүй, оюун санааны есон дэвшил" гээд миний сургалт байдаг юм. Монгол эр хүний сэтгэхүйн онцлогт суурилсан энэхүү хөтөлбөрөөр тэднийг эргэж хол дээрээ босоход нь тусалдаг.

**-Сэтгэл зүй, оюун санааны есон дэвшил"-ээр чухам юуг заадаг юм бол?**

-Эхлээд хүн өөрөө чин сэтгэлээсээ архинаас татгалзах хэрэгтэй. Ингэж шийдэж сэтгэл зүйгээ удирдан жолоодож чадсан хүн л архинд донтох өвчнөөсөө салж чадна. Ийм эргэлт буцалтгүй шийдвэрийг өвчтнөөр өөрөөр нь гаргуулах ёстой. Дараа нь өөрийгөө хайрлах ёстой гэдгийг ойлгуулдаг.

# ЧУХАЛ ХҮН

## СЭТГЭЛИЙН ДЭМ, ИХ ХЭРЭГТЭЙ

нас хайр сэтгэл гэдгийг жинхэнэ утгаар нь мэдэрч гэр бүл болж байлаа. Сайхан ханиа мөнх бусад алдчихаад гурван жил ганцаараа үйлж явсан. Тэр үедээ хэнд ч үнэн үгээ хэлдэггүй, их ганцаардлын байдалд орсон доо. Хүн хэтэрхий их дотогшоогоо чингэж бөглөрөөд яваад байхаар зүрх ачааллаа даадаггүй юм билээ. Улмаар даралт ихэсдэг, зүрх өвддөг болсон. Ерөнхийдөө л сул дорой нэгэн болчихсон байлаа. Би ингээд дуугарчихвал дэмий байх. Тэгээд хэлчих үү. За за яришиг гээд юм болгоныг буруу талаас нь боддог болчихсон үе надад бас байсан. Гэтэл 2010 онд байгууллага маань намайг сургалтад суулгахаар явуулдаг юм байна. Тэр сургалтад сууснаар би хамгийн түрүүнд өөрийгөө өөрчилсөн. Яагаад гэвэл би нутаг холтой. 10 хүүхэдтэй айлын хамгийн том. Өөрөө дөрвөн хүүхэдтэй. Хань маань найман хүүхэдтэй айлын хамгийн том нь байсан. Тиймээс би амьдралд нугарч болохгүй юм байна. Би сэтгэлзүйгээр баян байх ёстой юм байна гэдгийг ойлгоод өөрийгөө эхлээд өөрчилсөн юм. Дараа нь би зөвхөн өөрөө сайн хүн болохдоо бас гол нь биш. Маш олон хүний сэтгэлзүйд нөлөөлж, гэр бүлд нь байр баясгалан, элэг бүтэн амьдралыг нь эргүүлж авчирья гэж шийдээд миний чин үүрэг болсон. Одоо би энэ ажлаараа бахархдаг. Маш олон хүний

амьдралд өөрчлөлт авчирч, гэрэл гэгээ тусгасан. Би хамт олноороо бахархдаг. Миний ядрах, жаргах тэр бүхэнд хамт олон маань миний дэргэд зогсч байсан. Би хамт олондоо маш их хайртай. Аав маань Хорих байгууллагын удирдах газарт насаараа ажилласан. Тиймээс би өөрийгөө аавынхаа үргэлжлэл шүү дээ хэмээн омогшуулдаг. Энэ байгууллагад би сэтгэлийн их өртэй хүн.

**...Зарим үйлчлүүлэгч “Эж ээ” гэж дууддаг. 2012 онд би “Мөрөөдлийн гүүр” нэвтрүүлэгт оролцсон. Эмчлэгдсэн хүмүүс намайг энэ нэвтрүүлэгт оруулсан юм. Намайг “Эж ээ” гэж дуудахаар дотроо би “Нээрээ, энэ хүн ээж ээ гэдэг үгнээс ухаарчих юм биш байгаа даа” гэж боддог...**

Олон дүүгийнхээ хажуугаар түмний сайхан үрсэд тус хүргэхийг хамгийн их хичээлээ. Зарим үйлчлүүлэгч “Эж ээ” гэж дууддаг. 2012 онд би “Мөрөөдлийн гүүр” нэвтрүүлэгт оролцсон. Эмчлэгдсэн хүмүүс намайг энэ нэвтрүүлэгт оруулсан юм. Намайг “Эж ээ” гэж дуудахаар дотроо би “Нээрээ, энэ хүн ээж ээ гэдэг үгнээс ухаарчих юм биш байгаа даа” гэж боддог. Би ээж шиг нь байх ёстой хүн шүү гэж өөрийгөө үргэлж цэнэглэж явдаг юм. Ямар урмын үг хэлэх вэ, яаж зөв чиглүүлж, зөв амьдруулах вэ гэж санаж сэрж суудаг.

**-Архинаас татгалзах эмчилгээнд хамрагдаж байгаа өвчтнүүдийн үйлчилгээний зардлыг хаанаас гаргадаг юм бол?**

Шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээ хийлгэж байгаа

...Зарим үйлчлүүлэгч “Эж ээ” гэж дууддаг. 2012 онд би “Мөрөөдлийн гүүр” нэвтрүүлэгт оролцсон. Эмчлэгдсэн хүмүүс намайг энэ нэвтрүүлэгт оруулсан юм. Намайг “Эж ээ” гэж дуудахаар дотроо би “Нээрээ, энэ хүн ээж ээ гэдэг үгнээс ухаарчих юм биш байгаа даа” гэж боддог...

учраас төрөөс л энэ хүмүүсийн эмчилгээ үйлчилгээний зардлыг гаргадаг. Манайд архины хордлого тайлах, шинж

тэмдгийг дарах, архины дур дарах эмчилгээг хийдэг юм. Лабораторийн шинжилгээгээр тухайн хүн архинд донтох өвчний хэвдгээр үе шатанд байна вэ гэдгийг оношлоод эмчилгээг дэс дараатай хийж байна. Үүний хажуугаар сэтгэлзүйн сургалт маш үр дүнтэй байгаа.

**-Өнөөгийн хүнд хэцүү цагт төр халамжлах ёстой иргэнээ халамжилж, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гэж оролдож байгааг ойлголоо. Харин ар гэрийн зүгээс нь ямар дэмжлэг байдаг вэ?**

Архинд донтох өвчтэй хүн эмчилгээнд хамрагдаж байх үед ар гэрийнхэн нь бидэнтэй холбогдон ирж “Энэ өвчин ийм учиртай юм шүү”, “Үүнийг нь анхаарч тал талаасаа анхаарч ажилла” гээд бидэнтэй хамтарвал тухайн гэр бүлд л аз жаргал нь очно. Ингэж нээлттэй хамтарч ажиллавал эмчилгээний үр дүн илүү өндөр. Ар гэрийн зүгээс хэрэгтэй үед нь түшигтэй байж чадвал тухайн өрх айл элэг бүтэн хэвээрээ үлдэнэ.

**-Цаг гарган ярилцсанд баярлалаа.**

Хэн ч байлаа зөв сэтгэлтэй, уйгагүй хөдөлмөрлөж чадвал аз жаргал аяндаа өөрөө ирнэ. Би үр хүүхэддээ сайн ээж нь, шавь нартаа сайн багш нь байхыг үргэлж хичээдэг. Хамт олноороо бахархаж, мөр зэрэгцэн ажиллаж байгаадаа талархаж явдаг.



### ГОВЬСҮМБЭР АЙМАГ

## Эрүүл мэндийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ой тохиож байна



Монгол Улсад 1921 оны наймдугаар сарын 15-нд Их жанжин Д.Сүхбаатарын шийдвэрээр цэрэг, ард иргэдэд үнэ төлбөргүй тусламж үзүүлэх “Өвчтэй хүмүүсийг эмчлэх хороо”-г байгуулж байсан тэр цаг үеэс хүн ардын эрүүлийг хамгаалах асуудлыг үзүүлж эхэлсэн Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн байгууллагын түүхт 90 жилийн ой болж өнгөрлөө. Баярын хурал энэ сарын 15-нд дуу бүжгийн “Боржигин” чуулгад ёслол төгөлдөр болж, аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам, аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэгтүмбэрэл, Сүмбэр сумын ИТХ-ын дарга Т.Түмэнбаяр, засаг дарга П.Амарсайхан, Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнх-ол, аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга С.Ариунгэрэл болон үе үеийн ахмад буурлууд, зочид төлөөлөгчид, ажилтан албан хаагчид оролцлоо. Түүхт 90 жилийн ойгоороо салбартаа үр бүтээлтэй ажилсан үе үеийн ахмад буурлууд, ажилтан албан хаагч нар төр засагтаа хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлж төрийн одон медаль, ЭМЯ-ны шагнал, аймаг, сумын Засаг даргын жууц, 90 жилийн ойн медалиар шагнагдлаа. “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар Эрүүл мэндийн газрын ахмад ажилтан Ж.Өсөхбаяр, “Эрүүлийг хамгаалахын

тэргүүний ажилтан”-аар С.Уранбилэг, Б.Одончимэг, С.Отгончимэд, Т.Тогтох, Д.Должинсүрэн, Г.Тэрбиш, З.Одончимэг, Б.Ичинхорлоо, Д.Лхагвасүрэн, Ц.Хүрэлбаатар, Д.Отгонбаяр, Ж.Нансалмаа, Н.Энэбиш, Д.Санжидмаа, Д.Наранчимэг, Л.Дэлгэр, Х.Ичинхорлоо, Б.Номин-Эрдэнэ, С.Амаржаргал, Р.Батцэцэг, С.Нямдаваа, М.Мариймаа, М.Оюунцэцэг, Ц.Таванцэцэг, Д.Дэлгэрмаа, Б.Өнөрцэцэг, Н.Нарантуяа, А.Пүрэвсүрэн, Б.Эрхцэцэг, У.Ундраа, С.Санрагчимэг, Д.Оюунчимэг, Ч.Түмэнбаяр, Ш.Апьяамаа нарын хүмүүс шагнагдлаа. ЭМЯ-ны “Жуух бичиг”-ээр Л.Алтантуяа, Г.Ганхуяг, А.Оюун-Эрдэнэ, Г.Булганжаргал, Н.Доржсүрэн, Б.Буянжаргал, Д.Баасанжаргал, У.Азжаргал, Х.Баярсахайн, Г.Бат-Ирээдүй нар шагнагдсан бол аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр Ц.Эрэнцэрлор, О.Цэрэнчимэд, Б.Болормаа нар шагнагджээ. Мөн “90 жилийн ойн медаль”-аар Я.Минжүүр, М.Эрдэнэбилэг, Д.Пунцагхорлоо, Л.Удвал, С.Ариунгэрэл, Л.Эрдэнэ, Б.Цэцэгмаа, Б.Минсэл, О.Одмандха, Г.Жамсран, О.Нямцэрэн, Л.Цэнд, Т.Адьяасүрэн, Ц.Долгор, Б.Сугармаа, Г.Цэнд, Д.Наран-цэцэг, Б.Нарангэрэл, Н.Ариун-сайхан, Р.Оролмаа, К.Кулимаш нарын 21 хүн шагнагдсан байна.

### ММ-ИЙН ТОДРУУЛГА

## Ц.ДУЛАМСҮРЭН: Шавжнаас ангижирах хамгийн үр дүнтэй арга нь ойн цэвэрлэгээг эхлүүлэх

*Богдхан уулын ой модыг цэвэрлэх шаардлагатай гэж ой хамгаалагчид болон иргэд ярьдаг. Үүнтэй холбогдуулан Богдхан уулын ДЦГ-ын Хамгаалалтын захиргааны дарга Ц.Дуламсүрэнгээс тодрууллаа.*

**-Богдхан ууланд гарсан түймэр зэргээс болж, цэвэрлэх шаардлагатай байгаа талаар хүмүүс ярьж байна. Яг одоо ойн цэвэрлэгээг хийх шаардлага байгаа юу?**

Ойгоор бүрхэгдсэн талбайн 98.8 хувь нь байгалийн 0.1 хувь нь таримал ой, 1.1 хувийг сөөг торлог эзэлдэг. Харин ойгоор бүрхэгдээгүй талбайн 8.4 хувийг буюу 241 га-г шатсан ой эзэлж байна. Унанги болон хөгширсэн мод их байгаа нь түймэр гарах, тархах, хөнөөлт шавж олшрох, голомт үүсэх нөхцөлийг бүрдүүлж, ойг нөхөн сэргээхэд хүндрэл учруулж байна. Тиймээс цэвэрлэх шаардлага нэн тэргүүнд тулгамдаж байгаа. Цэвэрлэггүй ой нь түймрийн аюулыг нэмэгдүүлдэг. Өнгөрсөн 70 жилд дэлхийн дулаарал 0.7 хэмээр нэмэгдсэн бол манай орны хувьд 2.1 хэмээр буюу даруй гурав дахин их байгаа нь түймэр гарах нөхцөлийг улам ихэсгэж байгаа юм. Түймэр нь ойн экосистемийг бүрдүүлэгч хүчин зүйлүүдийн оршин тогтнох чадвархид сөргөөр нөлөөлж, шатсан ойд хортон шавж үржих, ойн өвчлөл гарах шалтгаан болохын дээр хүн ам, нийгэм, эдийн засагт ноцтой хохирол учруулж байна. Түүнээс гадна ойн сангийн 76 хувийг болц гүйцэж хөгширсэн, ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд удаа дараа нэрвэгдсэн

мод эзэлж байна. Үүнээс гадна цэвдэгт хөрс багасч хүчтэй салхинд мод унах үзэгдэл сүүлийн жилүүдэд ажиглагдах боллоо. Энэ нь ойн төлөв байдалд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна. Мөн цэвэрлэггүй ой нь үндэс, гол иш, модлогоор хооллогч 160 орчим зүйлийн хөнөөлт шавжийн тоо толгой хэт олшрох таатай нөхцөлийг бүрдүүлж, ойн экосистемийг эмзэг болгодог.

**-Ойн цэвэрлэгээний ажлын өнөөгийн байдал ямар байгаа вэ?**

Ойг эрүүлжүүлэх, ойн эмгэгээс сэргийлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилготой цэвэрлэгээний арга хэмжээг бодлогын хэмжээнд тавих шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Улсын хэмжээнд жилд бэлтгэх модны дээд хязгаарыг тогтоож байгаа нь тухайн жилийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хэрэглээний болон түршний модны хэрэгцээнд зориулагдаж, харин ойн төлөв байдлыг сайжруулах, нөхөн сэргэх нөхцөлийг хангах цэвэрлэгээний ажилхийг дэхгүй өнөөдрийг хүрсэн.

**-Ойг цэвэрлэсний ач холбогдлын талаар тодруулахгүй юу?**

Ойг цэвэрлэсэн ой санг хамгаалах, эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах ач холбогдолтой. Ойн цэвэрлэгээ хийснээр хулгайн мод, түймэр, хортон шавж багасна. Унасан, хатсан мод нь ойн түймрийг тэтгэх маш том хүчин зүйл. Унанги, хатсан мод нь амьд мод хооронд маш хурдан гал дамжуулах механизм болдог учир ойн түймрийн эрсдэлийг нэмэгдүүлдэг. Сүүлийн 10 жилд 100 мянган га-д тохиолдох



ойн түймрийн давтамж 1.4-7.3 байгаа нь шатамхайн дунджаас их зэрэглэлд шилжсэн. Энэ нь нэг га дахь унанги модны нөөц буюу шатах материалын нөөц 2-3 дахин нэмэгдсэнтэй холбоотой. Ойд цэвэрлэгээ хийвэл түймрийн тоог хоёр дахин, түймэрт өртөх ойн талбайн хэмжээг 3-4 дахин бууруулах боломж бүрдэнэ. Мөн шинэс, нарсны түймэрт тэсвэрлэх чадавхийг хоёр дахин нэмэгдүүлнэ. Хортон шавжны үүрлэг, үрждэг орчин нь хатсан унанги мод. Ялангуяа түүн дээр модлог идэшт хортны өндөг, авгалдай бойжиж, өсөж үрждэг гэж манай ойн мэргэжилтнүүд хэлдэг. Цаашид ойн шавжнаас ангижирахыг хүсвэл үүрийг нь цэвэрлэх хэрэгтэй.

**-Гал түймэр гарахаас өөр ямар хүчин зүйлээс болж ой бохирддог вэ?**

Монгол Улсын нийт нутгаар тархаад байгаа өрөөсгөл хүр эрвээхэй нь нэг жилийн хөгжлийн үе шаттай бөгөөд хэт олширлын үедээ ойд маш хөнөөлтэй, ой модонд үүрлэг, модыг эргэн төлжихгүйгээр

гэмтээдэг. Мөн самар түүгчдийн асуудал байна. Хуш модноос самар унагаахын тулд болц гүйцээгүй байхаас нь авахуулж түншиж нүдсээр самар нөөц 2-3 дахин нэмэгдсэн болц том том холтой, мөчиртэй нь хугалаад авч байна. Ингэж самар түүсэн тохиолдолд тэр модонд дахиад хэзээ ч самар ургахгүй. Ой хээрийн түймрүүд ихэвчлэн хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болж гарч байгаа нь харамсалтай. Татсан тамхины иш, түлсэн галаа унтраалгүй орхих, самар түүгчдийн отог зэргээс голчлон гал алдсан нь илэрдэг. Түүнээс гадна ой хамгаалах нэрийн дор хав дарж, ой хамгааллын нөхцөлийг “муутгадаг” гаж тогтолцоо оршиж байна. Үүнийг өөрчлөх оролдлогын нэг эхлэл нь ойн цэвэрлэгээ юм. Ойг цэвэрлэж байгаа нь энэ гээд олон нийтийн бодож байгаа шиг тасдаад, хяргаад байх асуудал байхгүй. Хөгшин, хатсан, унанги модыг цэвэрлэж, горимын дагуу нөхөн сэргээлт хийхийг хэлдэг гэдгийг ойлгох хэрэгтэй.

### ОРХОН АЙМАГ

## Үерээс учирсан хохирлын хэмжээг тогтоохоор ажиллаж байна

Эрдэнэт хотод энэ сарын 14-ний өдрийн 04:30 цагаас эхлэн орсон түр зуурын хүчтэй мөндөр, аадар борооны улмаас гэр хорооллын зарим айл, өрх гудамжууд усанд автаж, үерийн ус зайлуулах суваг шуудуу, нүхэн гарцууд зарим хэсэгтээ ачааллаа даалгүй эвдэрч сүйджээ. Тодруулбал, Булаг багийн автозам дээр лаг шавар, шороо чулуу урсаж орж ирсний улмаас замын зорчих хэсэгт автомашин зорчиход хүндрэл үүсгээд байсныг аймгийн Хот тохижуулах газрууд ажиллагсад шөнө цэвэрлэж, автомашин зорчих боломжтой болгожээ. Түүнчлэн аймгийн удирдлагууд болон Онцгой комиссын гишүүд шөнө ажиллаж, шуурхай арга хэмжээ авчээ. Мөн аймгийн Онцгой комисс яаралтай хуралдаж, холбогдох байгууллагын удирдлагуудад үүрэг чиглэл өгч ажилласан бол очигдөр аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал, ЗДП-ын дарга Д.Соёлчхүү нараар удирдуулсан Онцгой комисс дахин хуралдаж үерийн гамшгаас үүссэн хохирол, эвдрэл гэмтлийг сэргээн засварлах ажлын явцын талаар хэлэлцжээ. Аймгийн ЗДП-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон холбогдох албадын мэргэжилтнүүдийн хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж хохирлын хэмжээг тогтоохоор ажиллаж байгаа бөгөөд урьдчилсан байдлаар 1.5 км орчим үерийн ус зайлуулах суваг шуудуу эвдэрсний сэргээн засварлах шаардлагатай, 12 багт 40 гаруй айлын бохир хальсан, 1300 ам.метр талбайд

ариутгал, халдваргүйтгэл хийх, хэд хэдэн орон сууцны зоорийн давхарт ус дүүрснийг соруулах, хавар тарсан шар хуайс болон ногоон байгууламжууд урсаж эвдэрснийг сэргээн засварлаж байна. Сэргээн засварлах ажилд хутагаат болон дүйцүүлэх цэргийн алба хаагчид, ЗХ-ний 186, 110 дугаар ангийн хүн хүч, техник, Дулаан оролцож буй хүмүүст хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүс ажлын бээлий, цэвэр ус, хоол хүнсний зүйлээр тусалж дэмжих аян өрнөж эхэлжээ. Тухайлбал, Шанд багт үерийн шуудуу сэргээн засч буй цэргийн алба хаагчдад тусалж буй ажиллагаа явуулдаг “Баян-Өндөр” минн маркет, 22 дугаар цэвэрлэг ажлын бээлий, 17 дугаар сургуулиас хүнсний зүйлээр туслахаа үзүүлжээ. Түүнчлэн цаашид буюу энэ сарын 24-ний өдрийг хүртэл цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээгээр 16, 17, 18, 19-ний үдээс хойш, 20-ны шөнөдөө түр зуурын дуу цахилгаантай ширүүн бороо, мөндөр орж, борооны өмнө салхи ширүүсэх бөгөөд 22-23-ны өдрүүдэд үргэлжилсэн хүйтэн бороо орно. Хөрсөн дээрээ шөнөдөө 9-14 хэм, 19-ний өдрөөс хойш шөнөдөө улам сэрүүсч 4-9 хэм хүртэл агаарын температур буурах төлөвтэй байгаа тул аж ахуйн нэгж, ард иргэдэд Ус цаг уур, орчны шинжилгээний газраас анхааруулж байгааг сануулсан юм.

# ЗАВСАРЛАГА

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

## “ХОХИРОГЧ”



Б.СУМЬЯА

Энэ зургийг Ассошэйтед пресс агентлагийн гэрэл зурагчин Даниэл Берехулак 2016 оны арваннэгдүгээр сарын 10-нд авчээ. Филиппинийн Манила хотод үл таних зэвсэглэсэн залууст буудуулж амиа алдсан

хохирогчийн цогцос нарийн гудамжинд хэвтэнэ. Түүний хажууд цагдаагийн ажилтан сууж, гэрэл тусгаж буй байдал зурагт дүрслэгджээ. “World press photo” гэрэл зургийн наадам 1955 оноос хойш жил бүр зохион байгуулагдсан бөгөөд энэ хугацаанд дэлхийн улс гүрэнд өрнөж буй нууцлагдмал асуудлыг гэрэл зургаар дамжуулан

олон нийгэд ил гаргасаар ирсэн байдаг.

Наадам нийт найман төрлөөр шилдгүүдэд тодруулдаг. Харин “World press photo-2017”-д 125 орны 5034 гэрэл зурагчин 80408 бүтээлээ илгээснээс дээрх зураг “Ерөнхий мэдээ” төрөлд нь тэргүүн байр эзэлж, хамгийн хүчтэй 17 зурагны нэгээр тодорсон байна.

Улаанбаатар:

Маргааш  
Өдөр +27  
Шөнө +14

Нөгөөдөр  
Өдөр +27  
Шөнө +14

### Өдрийн зурхай

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:  
Нүд бүрэлзэн улцайна

Наран ургах, шингэх:  
05.54-19.59



Тухайн өдөр бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, гарагийг тахиx, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, төлөг тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахна болой. Хол газар яваар одогсоод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Бидэнд тохиолдсон

**MUNKH AMAR**

Хүндхэн хөгтэй явдлууд

Лаа гэмээнэ лаа юм аа гэж

Миний нэг танил эгч халуураад, хүүхдүүд нь аав руугаа “Ээж өвдөөд байна” гэж хэлсэн юм байх. Тэгсэн чинь аав нь “Миний хүүхдүүд лаа хий. Удахгүй очлоо” гэжээ. Тэгээд ажлаасаа чөлөө аваад яараад давхиад ирсэн чинь

эхнэр нь халуурсан янзаараа хүү нь харин лаа үзүүрлээд сууж байна гэнэ. “Миний хүүхдүүд лаа хийхгүй яасан юм бэ” гэсэн чинь “лаагүй олдоггүй, сая л оллоо” гэж хариулжээ. Амжиж ирээгүй бол янзын юм болох байж. Ккк

ДУУЛГАХ СОНИН

### “БИГ-БЕН”-ийг 2021 он хүртэл зогсооно

Их Британийн парламентын ордны дээр байдаг алдарт цаган цамхгийн доторх “Биг-Бен” хонх засварын ажлын улмаас дөрвөн жилийн турш дуугарахгүй болжээ. “Биг-Бен” хонх, цаг болон Их Британийн хамгийн алдартай барилгыг өөртөө хамааруулдаг бөгөөд энэ сарын 21-ний даваа гарагаас эхлэн их засварт орох аж. Тиймээс цаг тутамд дуугардаг тус цамхгийн хонхыг 2021 он хүртэл зогсоохоор шийдсэн байна. Гэхдээ “Биг-Бен”-ийг тэмдэглэлт баяраар, тухайлбал Зул сарын баяраар

дуугаргаж байх ажээ. “Биг-Бен” нь 13.7 тн жинтэй бөгөөд цаг тутамд дуугардаг бол дөрвөн талд нь байрлах тус бүр нь 1-4 тн жинтэй дөрвөн хонх нь 15 минут тутамд дуугардаг аж. “Биг-Бен” нь 157 жилийн турш бараг зогсолтгүй ажилласан байна. Хамгийн сүүлд 2007 онд ээлжит засварын ажил хийхэд цагийг зогсоож байжээ. Мөн 1983 болон 1985 онд сэргээн засах гэж цаг, хонхыг зогсоож байсан гэнэ.

## ТЭНГИС КИНОТЕАТР

<p><b>Annabelle 2</b></p> <p>10:45 13:00 15:10 17:25 18:20 VP 18:40 19:50 20:50 22:10 23:00</p>	<p><b>The Dark Tower</b></p> <p>12:45 14:50 16:20 VP 19:05 21:00 22:50 VP</p>	<p><b>"Valerian" YCK</b></p> <p>10:30 16:00 18:20 23:00</p>	<p><b>"DUNKIRK" YCK</b></p> <p>12:00 VP 16:50</p>
<p><b>War for the Planet of the Apes</b></p> <p>10:40 13:20 15:05 19:40 20:55 22:25</p>	<p><b>Spider-Man: Homecoming</b></p> <p>15:50</p>	<p><b>Despicable Me 3</b></p> <p>11:20 13:10 17:50</p>	<p><b>Transformers: The Last Knight</b></p> <p>13:00</p>

FOOTBALL NEWS

### Усайн Болт “МАНЧЕСТЕР ЮНАЙТЕД”-ын төлөө тоглоно

Хөнгөн атлетикийн спортын домогт тамирчин Усайн Болт “Манчестер Юнайтед”-ын төлөө тоглож, мөрөөдлөө биелүүлж магадгүй байна. Тодруулбал, тэрбээр ирэх сарын 2-нд “Олд Траффорд” цэнгэлдэхэд болох “Манчестер Юнайтед” болон “Барселона” багуудын домгуудын хооронд болох хандивын тоглолтод оролцох боломжтой аж.



Түүнийг энэ тоглолтод оролцуулах боломж байгаа талаар “Манчестер Юнайтед” клубын удирдлагууд хэлсэн юм байна. Харин домогт гүйгч Болт “Хүн бүхэн л намайг хөлбөмбөг тоглох хүсэлтэй байдгийг минь мэдэх байх. Одоо бол би Моурингоос дуудлага хүлээгээд л утсаа хараад сууж байдаг ажилтай болсон. Ямар ч байсан цаадах чинь наймааны цонх хаагдахаас өмнө надтай холбогдох байх” хэмээн ярьсан байна.

### ОКСЛЕЙД-ЧЕМБЕРЛЕН “Челси”-гээс долоо хоногт 150 мянгыг авахыг хүсч байна

Лондон хотын “Арсенал” клубын хагас хамгаалагч Алекс Окслейд-Чемберлен “Челси” клуб руу явах боломжтой байгаа. Тэгвэл тэрбээр “Цэнхэрүүд”-ээс өндөр цалин авахыг хүсч буй аж. Тодруулбал, тэрбээр долоо

хоногтоо 150 мянган фунт стерлинг авах хүсэлт тавьжээ. Окслейд-Чемберлен “Арсенал”-аас долоо хоногтоо 65 мянган фунтын цалин авдаг юм. “Арсенал”-ын хувьд түүнийг 35 саяар үнэлж байгаа билээ.